

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ийн  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ



ХУНАН ИНДАСТРИАЛ  
ЭКҮЙПМЕНТ ИНСТАЛЭЙШН ХХК-ийн  
ТӨЛӨӨЛӨГЧ ГАО БО



## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2023 оны 04 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар 2023/24

Улаанбаатар хот

2023 оны 04 сарын 21

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК /цаашид “Захиалагч” гэх/түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, нөгөө талаас Хунан Индастриал Экүйпмент Инсталэйшн ХХК /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар /цаашид хамтад нь “талууд” гэх/ харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл болон холбогдох бусад хууль эрх зүйн актыг удирдлага болгон энэхүү гэрээг байгуулав.

1.2 Гүйцэтгэгч нь захиалагчийн ажлын даалгаврын дагуу гэрээний хугацаанд үйлдвэрийн хашаанд хуучин барилгыг засварлаж АДС ТӨХК-ийн 116 МВТ-ын өргөтгөлийн төслийг хэрэгжүүлэх явцад ажилчдын дотуур байр, гал тогоо, склад, оффисын зориулалтаар тохижуулах барилгын ажил болон холбогдох бусад ажлыг хийж гүйцэтгэн Захиалагчийн өмчлөлд шилжүүлнэ.

1.3 Гүйцэтгэгч захиалагчийн ажлын даалгаварыг хавсралтад заасан ажлыг гүйцэтгэнэ. Хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

### Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Гэрээний ерөнхий хугацаа нь 30 хоног байна.

2.2 Гэрээний эхлэх хугацаа: 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр

2.3 Гэрээний дуусах хугацаа: 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

2.4 Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээний хугацааг сунгах эсэх асуудлыг энэхүү гэрээний

2.3.-г заасан хугацаа дуусахаас өмнө харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

### Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

3.1 Гүйцэтгэгчийг үүргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт болон бусад мэдээллийг өгөх үүрэгтэй.

3.2. Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд саад болохгүйгээр ажлын гүйцэтгэлд хяналт тавих, гүйцэтгэлийг чанартай, зохих ёсоор гүйцэтгэхийг шаардах, шаардлагатай бол ажлын гүйцэтгэлийг ажлын даалгаварт зааснаар залруулахыг шаардах, шаардлагаа гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэх эрхтэй.

3.3. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол илэрвэл ажлыг хүлээн авсан даруй шалгаж, доголдлыг арилгуулах эрхтэй.

3.4. Ажил гүйцэтгэгчийн тавьсан шаардлагын дагуу чанар муутай буюу шаардлага хангахгүй материалыг сольж өгөх, буруу зааварчилгаагаа өөрчлөх, ажлын чанар үр дүнд муугаар нөлөөлөх бусад нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

3.5. Гүйцэтгэгчид ажил үүргээ гүйцэтгэхээс өмнө ажлын байрны анхан шатны зааварчилгаа өгөх үүрэгтэй.

3.6. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг комисс гарган хугацаанд нь хүлээн авах үүрэгтэй.

### **Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

4.1. Гэрээнд заасан ажлыг захиалагчийн гаргасан ажлын даалгаврын дагуу тогтоосон хугацаанд биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.

4.2. Захиалагчийн ажлын байранд ажиллаж байхдаа хөдөлмөрийн дотоод журам, дүрэм, зааврыг ажилтнуудын нэгэн адил чанд баримтлан ажиллах үүрэгтэй.

4.3. Ажлыг захиалагчийн хүсэлт, ажлын даалгаварт заасны дагуу тухай бүр танилцуулна.

4.4. Гэрээнд заасан баталгаат хугацаанд захиалагчийн шаардлагаар сайжруулсан загварыг үнэ төлбөргүй, шуурхай гүйцэтгэнэ.

4.5. Ажил гүйцэтгэх гэрээг дуусгавар болгох үед гүйцэтгэгч нь захиалагчаас ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байсан тухай болон түүний үргэлжилсэн хугацааны талаар бичгээр тодорхойлолт гаргаж өгөхийг шаардах эрхтэй.

4.6. Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нөхцөл байдал бий болсон бол захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

### **Тав. Нууцлал хадгалах**

5.1. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан үүргээ биелүүлэх явцад олж мэдсэн бүхий л нууц мэдээллийг гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр мэдээлэх, дамжуулах, тараахыг хатуу хориглоно. Тараасан бол холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хариуцлага хүлээнэ.

### **Зургаа. Талуудын хариуцлага**

6.1. Хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас аль нэг талд хохирол учирсан тохиолдолд уг хохирлыг гэм буруутай тал нь бүрэн хариуцаж арилгах үүрэгтэй.

6.2. Гүйцэтгэсэн ажлын үр дүн доголдолтой бол гүйцэтгэгчийн зардлаар уг доголдлыг арилгуулна.

**Долоо. Гэрээ хүчин төгөлдөр болох**

7.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, өөрсдийн тамга /тэмдэг/-аар албажуулснаар хүчин төгөлдөр болно.

**Найм. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

8.1. Гэрээний хугацаа, нөхцлийн талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

8.2. Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

**Гэрээ байгуулсан:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ТӨСЛИЙН АХЛАХ  
ИНЖЕНЕР

ХУУЛИЙН  
МЭРГЭЖИЛТЭН



Э.МӨНХЖАРГАЛ



Ш.БАЯНМӨНХ



Г.САРУУЛ

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ХУНАН ИНДАСТРИАЛ ЭКҮЙПМЕНТ  
ИНСТАЛЭЙШН ХХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧ

ГАО БО



Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646



### **1. Шал**

А барилгын суурийг цементээр хучиж, PVC шалны материал ашиглана. /2мм зузаанаар хучна./

Б байрны шалыг 100-н зузаантай нарийн чулуун бетоноор хийж, гадна гадаргууг 1:1 харьцаатай цементэн элс цацаж, бүрэн өнгөлнө.

Хөнгөн DSP хуваалтын ханаар өрөө хоорондыг тусгаарлах бөгөөд ханын 75\*45\*0,6 хэмжээтэй, гипсэн хавтангийн зузаан нь 12 мм байна.

Ариун цэврийн өрөө, душны өрөөнд усны хамгаалалттай гипсэн хавтанг ашиглана.

### **2. Дээвэр**

Дээврийн засварыг ус гоожихгүй чанартай материалаар хийж гүйцэтгэнэ. Баталгаат хугацаа 1 жил байна.

### **3. Тааз**

Гипсэн хавтанг ашиглана. Дүүжин таазны ард өндөр нь 2,8 метрээс багагүй байна.

00, Угаалгын өрөөний тааз нь PVC хавтангаар хийгдэнэ.

### **4. Дотор хана**

А,Б байрны дотоод ханыг цагаан эмульсээр өнгөлнө.

### **5. Гадна хана**

А,Б байрны гадна ханыг бүрэн цементэн зуурмагаар өнгөлнө, суурь цэвэрлэж тэгшилгээ хийнэ.

Гадна ханыг саарал өнгөөр будна.

### **6. Хаалга, цонх**

Дотор хаалга хөнгөн мод, дотор цонх хуванцар гангаар хийгдсэн байна.

### **7. Гэрэлтүүлэг**

Таазны гэрэл хийнэ.

### **8. Угаалтуур**

Зэвэрдэггүй гангаар хийсэн угаалтуур суурилуулна.

### **9. Халаах хэрэгсэл**

Барилгын халаалтыг станцын халаалтын системд холбож оффиссын талбай, дотуур байрны өрөө тус бүрт радиотар суурилуулж, халаалтын өгөх буцах шугамд холбоно.

